



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/195

Улаанбаатар хот

Судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4 дэх заалт, Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3.2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны "Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай" 19 дүгээр тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны "Зардлын хуваарилалт батлах тухай" А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Шинжлэх ухааны паркийн захиргааны "Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн төсөл, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, сайжруулахад чиглэсэн судалгаа"-ны ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх 70'000'000 (далан сая) төгрөгийг Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 2022 оны төсвийн зардлын хуваарилалтын 1.2 дахь хэсгийн 4-т заасан зорилтот төслийн зардлаас санхүүжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын алба /Д.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох этгээдтэй судалгааны дэмжлэг үзүүлэх ажлын гэрээг байгуулж, 2022 оны 9 дүгээр сард багтаан чанартай, шуурхай зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

4. Судалгааны ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Баттогтох/-т үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210827